



## ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар А/87

Улаанбаатар хот

### ТУШААЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Жагсаалт, журам батлах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/221 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох "Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт"-д дараах нэмэлт оруулсугай. Үүнд:

1. 1."Хөдөлмөрийн хортой нөхцөл"-ийн 2.34 дэх хэсгийн 1 дүгээр мөрийн "Бутлах тээрмийн машинч" гэсний ард "бутлуурчин" гэж, 11 дүгээр мөрийн "Цахилгаанчин" гэсний ард, "цахилгаан тоног төхөөрөмжийн засварчин" гэж тус тус нэмсүгэй:

1. 2."Хөдөлмөрийн хортой нөхцөл"-ийн 2.34 дэх хэсэгт дараах агуулга 20 дугаар мөр нэмсүгэй:

20	Операторч, хүнд даацын авто машины	8332-12	Хүнд даацын авто машины жолооч /Белаз 100.1 тн-оос их/,
----	------------------------------------	---------	---

1. 3."Хөдөлмөрийн хортой нөхцөл"-д дараах агуулга бүхий 2.43 дахь хэсэг нэмсүгэй:

2.43. Эрчим хүчний үйлдвэрлэлийн			
1	Хими цехийн аппаратчин		Хими цехийн аппаратчин

1.4."Хөдөлмөрийн халуун нөхцөл"-ийн 3.1 дэх хэсэгт дараах агуулга бүхий 15, 16 дугаар мөр нэмсүгэй:

15	Машинч, салхивч ба тоос сорох тоног төхөөрөмжийн /цахилгааны/	7412-15	Зуухны цехийн тоосны системийн машинч
16	Турбин цехийн турбины машинч		Турбин цехийн турбины машинч

1.5."Хөдөлмөрийн халуун нөхцөл"-ийн 3.1 дэх хэсгийн 3 дугаар мөрийн "Зуухны цехийн засварчин" гэсний ард "турбин цехийн засварчин (тохируулга тосолгооны, арматур, шугам хоолойн, машинт тоноглолын)" гэж, 9 дүгээр мөрийн "Мастер" гэсний ард "турбин цехийн мастер (тохируулга тосолгооны, арматур, шугам хоолойн, машинт тоноглолын)" гэж, 10 дугаар мөрийн "Зуухны цахилгаан ба хийн гагнуурчин" гэсний ард "турбин цехийн цахилгаан ба хийн гагнуурчин", "турбин цехийн гагнуурчин, үрэлтийн аргаар гагнах" гэж тус тус нэмсүгэй.

1.6."Хөдөлмөрийн халуун нөхцөл"-ийн 3.2 дахь хэсгийн 23 дугаар мөрийн "Баяжмал хатаагч" гэсний ард "баяжуулах үйлдвэрийн хатаагч" гэж нэмсүгэй.

1.7."Хөдөлмөрийн халуун нөхцөл"-ийн 3.2 дахь хэсэгт дараах агуулга бүхий 43 дугаар мөр нэмсүгэй.

43	Гол баригч	7211-20	Засвар механикийн заводын гол баригч
----	------------	---------	--------------------------------------

1.8."Хөдөлмөрийн хүнд нөхцөл"-ийн 4.3 дахь гарчиг хэсгийн "Төмөр замын" гэсний ард "нисэхийн" гэж, мөн хэсэгт дараах агуулга бүхий 71, 72, 73, 74, 75, 76, 77, 78 дугаар мөр тус тус нэмсүгэй.

71	Жолооч-операторчин (агаарын хөлөгт контейнер, задгай тавцант ачаа ачигч автомашины, механизмын)		Жолооч-операторчин (агаарын хөлөгт контейнер, задгай тавцант ачаа ачигч автомашины, механизмын)
72	Аэродром үйлчилгээний жолооч-механизмчин (аэродром талбайн арчилгаа, үйлчилгээний хүнд автомашин, механизмын)		Аэродром үйлчилгээний жолооч-механизмчин (аэродром талбайн арчилгаа, үйлчилгээний хүнд автомашин, механизмын)

73	Тусгай тоноглолтой автомашины инженер-жолооч операторчин (агаарын хөлөгт мөстөлтийн эсрэг шингэн цацах автомашины)		Тусгай тоноглолтой автомашины инженер-жолооч операторчин (Агаарын хөлөгт мөстөлтийн эсрэг шингэн цацах автомашины)
74	Аэродромын албаны аэродромын ажилчин		Аэродромын албаны аэродромын ажилчин
75	Талбайн үйл ажиллагаа, хяналтын тасгийн дарга		Талбайн үйл ажиллагаа, хяналтын тасгийн дарга
76	Талбай үйлчилгээ, мөстөлт хяналтын диспетчер		Талбай үйлчилгээ, мөстөлт хяналтын диспетчер
77	Ачаа тээш хүргэгч	9621-13	Тээш түгээгч /төмөр замын/
78	Тасалбар шалгагч, нийтийн тээврийн	5112-13	Тасалбарын явуулын нярав /төмөр замын/

1.9."Хөдөлмөрийн хүнд нөхцөл"-ийн 4.4 дэх хэсгийн 1 дүгээр мөрийн "Мастер" гэсний ард "туслах, ажилтан" гэж нэмсүгэй.

1.10."Хөдөлмөрийн хүнд нөхцөл"-ийн 4.4 дэх хэсэгт дараах агуулга бүхий 13 дугаар мөр нэмсүгэй.

13	Мод хураагч, цавчигч	7521-19	Мод хураагч-цавчигч
----	----------------------	---------	---------------------

1.11."Хөдөлмөрийн хүнд нөхцөл"-ийн 4.23 дахь хэсэгт дараах агуулга бүхий 18 дугаар мөр нэмсүгэй.

18	Замчин		Замчин
----	--------	--	--------

2."Хөдөлмөрийн хүнд нөхцөл"-ийн 4.1 дэх хэсгийн 61, 137, 156 дугаар мөр, 4.2 дахь хэсгийн 87 дугаар мөр, 4.3 дахь хэсгийн 25 дугаар мөрийн "Шалгагч, төмөр замын үйлчилгээний (ачааны)-4323-25-Ачаа-вагон хүлээлцэгч (Шарын гол, Шивээ-Овоо, Хөтөл, Айраг, Бор-Өндөр, Өргөн өртөөний, Багануур өртөөний)" гэсний "(Шарын гол, Шивээ-Овоо, Хөтөл, Айраг, Бор-Өндөр, Өргөн өртөөний, Багануур өртөөний)" гэснийг тус тус хассугай.

САЙД Х.БУЛГАНТУЯА